



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар A/09

Хэрлэн сум

Г Мал, амьтны гоц халдварт өвчинтэй
тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дах заалт, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн Баянхутаг, Мөрөн, Дэлгэрхаан сумын нутаг дэвсгэрт гоц халдварт бог малын мялзан өвчин бүртгэгдэж, цаашид гаралт, тархалт нэмэгдэх эрсдэлтэй байгаа тул уг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж бэлтгэл бэлэн байдлын нөөцийг бүрдүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Бог малын мялзан өвчинтэй тэмцэх зааврын дагуу холбогдох арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж, халдварыг голомтод нь цомхотгон дарах, цаашид үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрт илрүүлэг эрүүл мэндийн үзлэг, тандалтыг оновчтой хэрэгжүүлэх, мэргэжлийн анги, багийг томилон хариуцлагыг өндөржүүлж ажиллахыг Баянхутаг, Мөрөн, Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Батноров сумын Засаг дарга нарт даалгасугай

3.Өвчнийг бүрэн хяналтад авах хүртэлх хугацаанд өвчин бүртгэгдсэн багаас бог мал түүний гаралтай бүтээгдэхүүний шилжилт, хөдөлгөөн, отор нүүдлийг хориглох, голомт, сэжигтэй бүсийн хүн, мал, тээврийн хэрэгсэлд тавих хяналтыг чангатгах, өвчний тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээнд гарсан зардлыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Гоц халдварт өвчний нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээлэл, урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар, зөвлөмжийг холбогдох байгууллага, малчид, иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр), Онцгой байдлын газар (Ж.Эрдэнэбат), сумын Засаг дарга нарт, орон нутагт ажиллаж буй цагдаагийн албан

2.

хаагчдыг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Батхүү)-т тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

